



ЗАВСРЫН ҮЕИЙН ХУРААНГУЙ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2021 болон 2022 оны 09 сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон гурав болон есөн сарын тайлан

*(Канад доллараар)
(Аудитаар баталгаажаагүй)*

Удирдлага бэлтгэв – Уншигчдад хүргүүлэх мэдэгдэлтэй танилцана уу

УНШИГЧДАД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ

National Instrument 51-102 Мэдээллийн ил тод байдлын үүрэг хариуцлага, 4-р хэсэг, 4.3 (3) а-д заасны дагуу хэрэв завсрын үеийн хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланг аудитор хянан, баталгаажуулаагүй тохиолдолд энэхүү мэдэгдлийг хавсаргах үүрэг хүлээдэг. Энэхүү аудитаар баталгаажуулаагүй завсрын үеийн хураангуй нэгтгэсэн тайланг Компанийн удирдлага бэлтгэв. Удирдлага нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорацийн 2021 оны 12 сарын 31 болон 2022 оны 9 сарын 30-ны байдлаар санхүүгийн тайланг нэгтгэн, 2021, 2022 оны 9 сарын 30-аар дуусгавар болсон 3 ба 9 сарын хугацааны нийт алдагдал, эздийн өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний мэдээллийг боловсруулсан. Компанийн хараат бус аудитор нь 2021, 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон завсрын үеийн хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийх, хянах болон ямарваа нэгэн байдлаар мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулаагүй болно. Уншигчдын зорилготой нийцэхгүй байх магадлалтай тул энэхүү мэдэгдлийг хүргүүлэв.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

	Тодруулга	2022.09.30	2021.12.31
Хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		\$ 2,980,543	\$ 7,063,051
Дансны авлага		52,323	23,784
Урьдчилж төлсөн авлага		1,336,575	1,012,450
Эргэлтийн хөрөнгийн дүн		4,369,441	8,099,285
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	6	42,844,131	37,928,453
Хөрөнгө ашиглах эрх	7	90,840	143,200
Үндсэн хөрөнгө	8	480,219	373,379
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		43,415,190	38,445,032
Нийт хөрөнгийн дүн		\$ 47,784,631	\$ 46,544,317
Өр төлбөр ба эздийн өмч			
Арилжаа болон бусад өглөг		\$ 640,442	\$ 660,456
Түрээсийн өмч	7	69,323	65,560
Богино хугацааны өр төлбөр		709,765	726,016
Түрээсийн өмч	7	31,295	86,281
Урт хугацааны өр төлбөр		31,295	86,281
Өр төлбөрийн нийт дүн		741,060	812,297
Эздийн өмч			
Хувьцаат капитал	10	\$ 151,727,982	\$ 145,153,510
Нэмж төлөгдсөн капитал	10	27,977,681	26,648,556
Бусад хуримтлагдсан алдагдал		(4,709,062)	(3,026,358)
Алдагдал		(127,953,030)	(123,043,688)
Эздийн өмчийн дүн		47,043,571	45,732,020
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		\$ 47,784,631	\$ 46,544,317

Гэрээгээр хүлээсэн үүрэг (Тодруулга 9)

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ийг төлөөлж баталсан:

Гарын үсэг зурсан "Жон П.Бюрн"

_____ ТУЗ-ийн гишүүн

Гарын үсэг зурсан "Кеннет В. МакДоналд"

_____ ТУЗ-ийн гишүүн

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, Нэгтгэсэн Алдагдлын Тайлан

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

Тодруулга	9.30-аас дуусгавар болсон гурван сар		9.30-аас дуусгавар болсон есөн сар	
	2022	2021	2022	2021
Үйл ажиллагааны зардал				
Хайгуул, үнэлгээний зардал	11 \$ 1,155,249	\$ 1,365,839	\$ 3,148,957	\$ 2,248,744
Ерөнхий ба удирдлагын зардал	12 870,287	565,092	1,791,332	1,594,223
Үйл ажиллагаанаас учирсан алдагдал	2,025,536	1,930,931	4,940,289	3,842,967
Санхүүгийн орлого	(26,588)	(10,957)	(37,858)	(47,565)
Хүүгийн зардал	2,524	1,602	9,039	5,200
Гадаад валютын ханшийн зөрүүнээс гарсан гарз (орлого)	(21,034)	14,222	(2,128)	30,802
Цэвэр алдагдал	\$ 1,980,438	\$ 1,935,798	\$ 4,909,342	\$ 3,831,404
Бусад дэлгэрэнгүй алдагдал (олз):				
Охин компанийн хөрвүүлгээс үүдсэн гадаад валютын ханшийн зөрүү	(68,953)	(452,098)	1,682,704	3,355
Бусад дэлгэрэнгүй алдагдал (олз)	(68,953)	(452,098)	1,682,704	3,355
Нийт дэлгэрэнгүй алдагдал	\$ 1,911,485	\$ 1,483,700	\$ 6,592,046	\$ 3,834,759
Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдал	\$ 0.01	\$ 0.01	\$ 0.02	\$ 0.01
Нийт хувьцааны жигнэсэн дундаж тоо	314,830,239	274,300,800	301,288,696	270,627,645

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

	Тодр уулга	Хувьцааны тоо ширхэг	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй алдагдал	Алдагдал	Нийт эздийн өмч
2021.01.01-ний үлдэгдэл		268,450,433	\$ 136,618,086	\$ 25,937,667	\$ (2,964,666)	\$ (117,473,165)	\$ 42,117,922
Тайлант хугацааны нийт алдагдал:							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(3,831,404)	(3,831,404)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	(3,355)	-	(3,355)
Хэрэгжүүлсэн опцион	10	900,000	492,275	(173,875)	-	-	318,400
Хэрэгжүүлсэн варрант	10	5,803,750	1,876,407	(135,282)	-	-	1,741,125
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр		-	-	988,538	-	-	988,538
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ		6,703,750	2,368,682	679,381	-	-	3,048,063
2021.09.30-ний үлдэгдэл		275,154,183	\$ 138,986,768	\$ 26,617,048	\$ (2,968,021)	\$ (121,304,569)	\$ 41,331,226
2022.01.01-ний үлдэгдэл		294,379,845	\$ 145,153,510	\$ 26,648,556	\$ (3,026,358)	\$ (123,043,688)	\$ 45,732,020
Тайлант хугацааны нийт алдагдал:							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(4,909,342)	(4,909,342)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	(1,682,704)	-	(1,682,704)
Хаалттай хүрээнд гаргасан хувьцааны цэвэр за	10	23,933,687	6,551,072	413,713	-	-	6,964,785
Хэрэгжүүлсэн опцион	10	60,000	23,400	(6,300)	-	-	17,100
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр		-	-	921,712	-	-	921,712
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ		23,993,687	6,574,472	1,329,125	-	-	7,903,597
2022.09.30-ний үлдэгдэл		318,373,532	\$ 151,727,982	\$ 27,977,681	\$ (4,709,062)	\$ (127,953,030)	\$ 47,043,571

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

	Notes	09.30-аар дуусгавар болсон гурван сар		09.30-аар дуусгавар болсон есөн сар	
		2022	2021	2022	2021
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Цэвэр алдагдал	\$	(1,980,438)	\$ (1,935,798)	(4,909,342)	\$ (3,831,404)
Мөнгөн бус гүйлгээнүүд:					
Элэгдэл, хорогдол		34,965	17,904	100,557	51,618
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр		763,718	298,375	921,712	988,538
Санхүүгийн орлого		(26,588)	(10,957)	(37,858)	(47,565)
Мөнгөн бус гадаад валют		(21,034)	14,222	(2,128)	30,802
Мөнгөн бус эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт		(519,363)	(138,892)	(382,735)	(328,935)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		(1,748,740)	(1,755,146)	(4,309,794)	(3,136,946)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Энгийн хувьцаагаар татан төвлөрүүлсэн цэвэр дүн		6,964,785	-	6,964,785	-
Опцион хэрэгжүүлсний төлбөр	10	-	-	17,100	318,400
Варрант хэрэгжүүлсний төлбөр	10	-	1,222,875	-	1,741,125
Түрээсийн төлбөрийн эргэн төлөлт		(16,023)	(7,029)	(46,844)	(20,691)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		6,948,762	1,215,846	6,935,041	2,038,834
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Хайгуул, хөрөнгийн үнэлгээний зардал	6	(2,612,643)	(2,135,342)	(6,555,922)	(6,871,310)
Үндсэн хөрөнгийн зардал	8	(69,297)	(63,486)	(185,837)	(99,127)
Хүүгийн орлого		26,588	10,957	37,858	47,565
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		(2,655,352)	(2,187,871)	(6,703,901)	(6,922,872)
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		40,414	(12,545)	(3,854)	(19,984)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт (бууралт)		2,585,084	(2,739,716)	(4,082,508)	(8,040,968)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эхэнд		395,459	7,499,476	7,063,051	12,800,728
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эцэст	\$	2,980,543	\$ 4,759,760	2,980,543	\$ 4,759,760

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулагдаагүй)

2021 болон 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын тайлан

1. Үйл ажиллагааны тайлан:

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” “Корпораци” эсвэл “Компани” гэх) нь Канад Улсад төвтэй, үнэт болон суурь металлын хайгуулын үйл ажиллагааг Монгол Улсад эрхэлдэг. Компанийн голлох төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт орших Баян Хөндий Алтны Төсөл юм. Компанийн үнэт цаас нь Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр “ERD”, Монголын Хөрөнгийн Бирж дээр “ERDN” тикертэйгээр арилжаалагддаг. Компанийн албан хаяг 1300-1969 Upper Water Street, Halifax, Nova Scotia, B3J 2V1 байрладаг.

2020 оны 08 дугаар сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. Компанийн үйл ажиллагаа үргэлжлэх, ашигт малтмалын өмчид капиталжуулсан хөрөнгийг нөхөн олох эсэх нь эдийн засгийн хувьд ашигтай нөөц, компанийн хайгуул, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүжилтийг олох чадвар болон үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашигтай байдал эсвэл нэг буюу түүнээс дээш хөрөнгийн худалдаанаас олсон орлого зэргээс хамаарна.

2. Тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчим

Энэхүү завсрын үеийн хураангуй нэгтгэсэн тайланг ирээдүйд үйл ажиллагааг үргэлжлүүлэх, бизнесийн хэвийн үйл ажиллагааны туршид хөрөнгийн өгөөжийг хүртэх, өр төлбөр, гэрээгээр хүлээсэн үүргээ үйл ажиллагааны хүрээнд биелүүлэх боломжтой гэх тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчимд тулгуурлан боловсруулав. Тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчим хэр зохистойг үнэлэхийн тулд гүйцэтгэх удирдлагын зүгээс тайлант хугацааны төгсгөлөөс хойш 12 сарын хугацааны мэдээллийг харгалзан үзсэн. Гүйцэтгэх удирдлага дүгнэхдээ үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхэд Компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болох үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдлуудыг тооцоолсон:

Компани нь 2020, 2021 оны 12 сарын 31 болон 2022 оны 9 сарын 30-р дуусгавар болсон завсрын үеийн тайлангийн хугацаанд алдагдалтай, сөрөг мөнгөн урсгалтай буюу 2022 оны 9-р сарын 30-ны байдлаар \$127,953,030-н алдагдалтай байна. Компанийн эргэлтийн хөрөнгө нь 2022 оны 9 сарын 30-ны байдлаар 2021 оны 12 сарын 31-ний \$7,373,269-аас \$3,713,593-аар буурч \$3,659,676 болсон. Удирдлагын тооцоолсноор одоогийн эргэлтийн хөрөнгө нь 2023 оны эхний улиралд төлөвлөсөн зардлыг санхүүжүүлэхэд хангалттай. Компанийн үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх нь хөрөнгөө баталгаажуулж бодит болгох, өр төлбөрөө барагдуулах, хайгуул, үнэлгээний хөтөлбөрөө үргэлжлүүлэн өргөжүүлэх ба өөрийн хөрөнгө болон санхүүжилтийн бусад хэлбэрийг баталгаажуулж, хамтын хөрөнгө оруулалт хийх зэрэг нь дээрх зарчмыг хангаж, үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд нөлөөтэй гэж гүйцэтгэх удирдлага тооцоолсон. Нэмэлт санхүүжилт нь зах зээлийн нөхцөл байдал болон Компанийн хэрэгжүүлж буй хайгуул, үнэлгээний хөтөлбөрийн үр дүнгээс шалтгаална. Компани нь ирээдүйд шаардлагатай хөрөнгийг татан төвлөрүүлэх чадвартай эсэхийг тооцоолох боломжгүй.

Хэрэв тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчмын төсөөлөл бодитой бус байсан бол хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланд шаардлагатай тохируулалтыг тусгаагүй. Тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчмын суурь нь бодитой бус байх тохиолдолд хөрөнгийн дансны үнэ, тайлагнасан орлого, зардал, санхүүгийн байдлын тайлангийн ангилалд тохируулга хийх шаардлагатай болно.

3. Тайлангийн үндэслэл

2022 оны 9 дугаар сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланг (“Завсрын үеийн санхүүгийн тайлан”) Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (“НББОУС”) 34 - завсрын санхүүгийн тайлагналын дагуу боловсруулсан. Завсрын үеийн санхүүгийн тайлан нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НББОУСЗ”)-ийн гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын дагуу боловсруулагдсан 2021 оны 12 дугаар сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан (“Жилийн эцсийн санхүүгийн тайлан”)-тай хамтад нь танилцах шаардлагатай.

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайланг тайлагнахыг 2022 оны 11 дугаар сарын 02-ны өдөр ТУЗ-өөр зөвшөөрсөн болно.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2021 болон 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын тайлан

4. Улирлын шинж чанар

Монгол Улс дахь цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан хайгуулын зардал, хайгуул үнэлгээний хөрөнгийн хөрөнгө оруулалтууд нь жилийн хоёр ба гуравдугаар улиралд төвлөрдөг тул компанийн үйл ажиллагаа нь улирлын шинж чанарыг агуулдаг.

5. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд

2022 оны 1 дугаар сарын 1-ээс дараах шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбар орж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Эдгээр өөрчлөлтүүдийг холбогдох шилжилтийн заалтуудын дагуу хийсэн.

НББОУС 16 – Үндсэн Хөрөнгө

2020 оны 5 сарын 14-нд ОУСБХБ-аас НББОУС 16 - Үндсэн Хөрөнгөнд нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд худалдан борлуулсан үндсэн хөрөнгө нь удирдлагаас тогтоосон үйл ажиллагааны нөхцөлд тохирох байршилд хүргүүлэх үед борлуулалтын орлогын дүнг үндсэн хөрөнгийн өртгөөс хасахыг хориглосон. Компани нь нэмэлт өөрчлөлттэй холбоотой санхүүгийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд энэхүү стандартыг мөрдөж эхэлснээр Компанид материаллаг өөрчлөлт ороогүй.

НББОУС 37 – Сан, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө

2020 оны 5 сарын 14-нд ОУСБХБ нь НББОУС 37 – Сан, болзошгүй өр төлбөр, хөрөнгөд нэмэлт өөрчлөлт оруулж, гэрээ нь нарийн түвэгтэй эсэхийг үнэлэх зорилгоор гэрээний биелэлтийн зардлыг тодорхойлоход аж ахуйн нэгж ямар зардлыг багтаахыг тодорхойлсон. Компани нь нэмэлт өөрчлөлттэй холбоотой санхүүгийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд энэхүү стандартыг мөрдөж эхэлснээр Компанид материаллаг өөрчлөлт ороогүй.

СТОУС 9 – Санхүүгийн хэрэглүүр

2020 оны 5 сарын 14-нд ОУСБХБ нь СТОУС 9 – Санхүүгийн хэрэглүүрт нэмэлт өөрчлөлт оруулж, санхүүгийн өр төлбөрийг тооцохгүй байх эсэхийг үнэлэх тестэд ямар төлбөрийг хамруулахыг тодорхойлж өгсөн. Компани нь нэмэлт өөрчлөлттэй холбоотой санхүүгийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд энэхүү стандартыг мөрдөж эхэлснээр Компанид материаллаг өөрчлөлт ороогүй.

Мөрдөгдөж эхлээгүй байгаа нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартууд

НББОУС-ийн дараах стандартууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхэд ашиглагдаагүй бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацаа нь тайлангийн үеийн дараагийн жилээс эхэлнэ.

НББОУС 1 – Санхүүгийн тайлангийн толилуулга

2020 оны 1 сарын 23-нд НББОУС нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгад өөрчлөлт оруулан, өр төлбөрийн ангиллыг илүү ерөнхий болгосон. Нэмэлт өөрчлөлтөөр өр төлбөрийг эргэлтийн болон эргэлтийн бус гэж ангилах нь өр төлбөрийг барагдуулах эрхийг хэрэгжүүлэх хүлээлтээс ялгаатай нь тайлант хугацааны эцэст үүссэн эрхээс хамаарна гэж тодотгосон. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр төлбөр тооцоо нь харилцагч тал руу бэлэн мөнгө, өмчийн хэрэгсэл, бусад хөрөнгө болон үйлчилгээг шилжүүлэхийг хэлнэ гэж тодотгосон. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2023 оны 1 сарын 1-ний өдрөөс хойш хүчин төгөлдөр мөрдөх бөгөөд энэхүү хугацаанаас өмнө даган мөрдөхийг зөвшөөрсөн. Компани нь одоогоор нэмэлт өөрчлөлттэй холбоотой санхүүгийн үр нөлөөг үнэлж байгаа бөгөөд энэхүү стандартыг мөрдөж эхэлснээр Компанид материаллаг өөрчлөлт орохгүй гэж үзэж байна.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

2021 болон 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын тайлан

6. Хайгуул, үнэлгээний хөрөнгө

	Баян Хөндий	Алтан Нар	Улаан	Зууд Мод ба бусад	Нийт
2021.01.01 үлдэгдэл	\$ 22,850,206	\$ 3,827,267	\$ 1,799,625	\$ 887,057	\$ 29,364,155
Нэмэгдэл	8,126,412	428,052	1,716	89,847	8,646,027
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(65,619)	(9,018)	(3,841)	(3,251)	(81,729)
2021.12.31 үлдэгдэл	\$ 30,910,999	\$ 4,246,301	\$ 1,797,500	\$ 973,653	\$ 37,928,453
2022.01.01 үлдэгдэл	\$ 30,910,999	\$ 4,246,301	\$ 1,797,500	\$ 973,653	\$ 37,928,453
Нэмэгдэл	6,264,092	236,753	1,726	53,351	6,555,922
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(1,351,635)	(162,998)	(65,893)	(59,718)	(1,640,244)
2022.09.30 үлдэгдэл	\$ 35,823,456	\$ 4,320,056	\$ 1,733,333	\$ 967,286	\$ 42,844,131

Компанийн Монгол Улс дахь ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг Компанийн охин компаниуд болох Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресорсиз ХХК, Лидер Эксплорэйшн ХХК эзэмшдэг. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл нь гурван жилийн хугацаанд хүчинтэй байх ба хугацааг 12 хүртэл жилээр сунгах боломжтой. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгодог бөгөөд 20 хүртэл жилээр 2 удаа сунгах боломжтой. Тусгай зөвшөөрлүүдийн жилийн төлбөрийг төлснөөр тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байна.

Баян Хөндий Алтны Төсөл

Баян Хөндий Алтны Төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт, 2,309 га Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршдог. 2019 оны 8 сард Монгол Улсын Ашигт Малтмал, Газрын Тосны Газар ("АМГТГ") нь Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийн хэсгийг хөрвүүлэх замаар ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон. Хөндий ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Roma Oil and Mining Associates Limited-ийн боловсруулж, 2020 оны 8 сарын 31-нд танилцуулсан "Bayan Khundii Gold Project Feasibility Study NI 43-101 Technical Report" нэртэй тайлан дахь Баян Хөндийн геологийн ба үйлдвэрлэлийн нөөцийг багтаасан. Компани нь одоогоор бүтээн байгуулалтын бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 2023 оны эхээр бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр төлөвлөж байна. Түүнээс гадна ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Хар Морь хэтийн төлөвт талбай багтдаг.

Алтан Нар Алтны Төсөл

Алтан Нар алтны төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт, Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий алтны төслөөс хойд зүгт 16 км-т оршдог. Эрдэнэ Ресурс нь алт, мөнгө, хар тугалга, цайрын нөөц бүхий Алтан Нар төслийг агуулсан 4,669 га талбайг хамрах Цэнхэр Номин хайгуулын тусгай зөвшөөрлийг Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл болгон, 2020 оны 3 сарын 5-нд Ашигт Малтмал Газрын Тосны Газар бүртгэсэн.

Улаан

Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайтай хил залгаа, нийт 1,780 га талбайг хамардаг. Хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 8 дахь жилдээ хүчин төгөлдөр байгаа бөгөөд Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу цаашид 12 жилийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэх боломжтой.

Зуун Мод Зэс Молибденийн Төсөл ба бусад

Зуун Мод төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт 6,041 га талбайг хамардаг бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайд молибден-зэсийн нөөц бүхий орд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд олгосон. Молибденийн зах зээлийн үнэ нэмэгдэх үед Зуун Мод зэс-молибденийн төслийг хөгжүүлэх боломжтой. 2021 оны эцэст Компани түүхий эдийн үнийн өсөлттэй холбогдуулан энэхүү төслийн стратеги болон эдийн засгийн үнэлгээг эхлүүлсэн. Компани нь технологи ба зах зээлийн хүчин зүйлсийг үргэлжлүүлэн судална.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

2021 болон 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын тайлан

7. Түрээс

Компани нь 2019 оны 9 сарын 1-ээс эхлэн 5 жилийн оффисийн түрээсийн гэрээ хийсэн. Түүнээс гадна Монгол Улсад 2021 оны 10 сарын 1-ээс эхлэн 2 жилийн оффисийн түрээсийн гэрээ хийсэн. Энэхүү түрээс нь баланс дээр түрээсийн өр төлбөр, хөрөнгө ашиглах эрх болон танилцуулсан. Түрээсийн хөнгөлөлт 7%, 15%-аар тооцсон.

Хөрөнгө ашиглах эрхийн талаар нэмэлт мэдээлэл:

2021.01.01-ний үлдэгдэл	\$	107,693
Нэмэгдэл		74,640
Элэгдэл		(38,703)
Валютын ханшийн зөрүү		(430)
2021.12.31-ний үлдэгдэл	\$	143,200
2022.01.01-ний үлдэгдэл	\$	143,200
Нэмэгдэл		-
Элэгдэл		(48,085)
Валютын ханшийн зөрүү		(4,275)
2022.09.30-ны үлдэгдэл	\$	90,840

2022 оны 9 сарын 30-ны байдлаар түрээсийн өр төлбөрийн хугацаа дуусах тухай:

	1 жилийн дотор	1 - 2 жил	Нийт
Түрээсний төлбөр	\$ 74,827	\$ 32,117	\$ 106,944
Санхүүгийн зардлууд	(5,504)	(822)	(6,326)
Нийт төлбөр	\$ 69,323	\$ 31,295	\$ 100,618

Компанийн Монгол Улс дахь оффис, ажилтнуудын байр болон агуулахын түрээс нь 12 сарын дотор хугацаа дуусна. Компани нь СТОУС 16-ын шаардлагыг эдгээр түрээсийн бүртгэлд тусгахгүй байхаар шийдсэн бөгөөд нийт \$73,502 (2021.09.30 - \$48,332) дүнтэй түрээсийн төлбөрийг зарлагдсанаар бүртгэсэн.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажаагүй)

2021 болон 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын тайлан

8. Үндсэн хөрөнгө

	Тээвэр	Хээрийн тоног төхөөрөмж, тоног төхөөрөмж, тавилга	Програм хангамж, компьютер	Нийт
Зардал				
2021.01.01-ний үлдэгдэл	\$ 131,748	\$ 191,144	\$ 223,953	\$ 546,845
Нэмэгдэл	-	139,997	39,332	179,329
Борлуулалт	-	(3,800)	(137,555)	(141,355)
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(905)	(1,019)	160	(1,764)
2021.12.31-ний үлдэгдэл	\$ 130,843	\$ 326,322	\$ 125,890	\$ 583,055
Элэгдэл ба хорогдол				
2021.01.01-ний үлдэгдэл	\$ (21,586)	\$ (86,568)	\$ (199,260)	\$ (307,414)
Элэгдэл	(12,970)	(15,792)	(15,047)	(43,809)
Борлуулалт	-	3,800	137,555	141,355
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	33	76	83	192
2021.12.31-ний үлдэгдэл	\$ (34,523)	\$ (98,484)	\$ (76,669)	\$ (209,676)
Дансны дүн				
2021.12.31-нд	\$ 96,320	\$ 227,838	\$ 49,221	\$ 373,379
	Тээвэр	Хээрийн тоног төхөөрөмж, тоног төхөөрөмж, тавилга	Програм хангамж, компьютер	Нийт
Зардал				
2022.01.01-ний үлдэгдэл	\$ 130,843	\$ 326,322	\$ 125,890	\$ 583,055
Нэмэгдэл	-	161,350	24,487	185,837
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(8,915)	(21,441)	(3,925)	(34,281)
2022.09.30-ны үлдэгдэл	\$ 121,928	\$ 466,231	\$ 146,452	\$ 734,611
Элэгдэл ба хорогдол				
2022.01.01-ний үлдэгдэл	\$ (34,523)	\$ (98,484)	\$ (76,669)	\$ (209,676)
Элэгдэл	(9,306)	(22,075)	(21,090)	(52,471)
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	2,514	3,180	2,061	7,755
2022.09.30-ны үлдэгдэл	\$ (41,315)	\$ (117,379)	\$ (95,698)	\$ (254,392)
Дансны дүн				
2022.09.30-нд	\$ 80,613	\$ 348,852	\$ 50,754	\$ 480,219

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулагдаагүй)

2021 болон 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын тайлан

9. Гэрээгээр хүлээсэн үүрэг

Компани нь Алтан Нар, Хөндий, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд 1%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр ("NSR")-ийг Сэндсорм-д төлөх үүрэг хүлээсэн. Сэндсорм нь дээрх тусгай зөвшөөрлийн хувьд ирээдүйн роялти ба стрийм санхүүжилттэй холбоотой давуу эрх эдлэх нөхцөлтэй.

Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд 1.5%-ийн NSR төлбөр төлөх үүрэгтэй. Энэхүү гэрээний хүрээнд Компани нь Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд олборлолтын тодорхой шатанд хүрснээр тодорхой хувийг эргэн худалдан авах эрх үүснэ.

10. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө

Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй.

Гаргасан хувьцаа

Компани нь 2022 оны 8 сарын 4-нд хаалттай хүрээнд нийт \$7,180,106 долларын санхүүжилт татан төвлөрүүлсэн. Хаалттай санхүүжилтийн хүрээнд Эрдэнэ Ресурс тус бүрийг \$0.30 доллараар үнэлсэн 23,933,687 ширхэг үнэт цаасны нэгжийг гаргасан. Үнэт цаасны нэгж бүр нь Компанийн нэг Энгийн хувьцаа болон Энгийн хувьцаа худалдан авах эрх болох хагас (½) Варрант ("Варрант")-аас бүрдсэн. Варрант бүр нь санхүүжилт хаагдсанаас хойш 2 жилийн хугацаанд нэг Энгийн хувьцааг \$0.45 доллараар худалдан авах эрхийг олгосон. Эрдэнэ Ресурс нь санхүүжилттэй холбоотойгоор \$151,048 доллар болон 236,826 ширхэг зуучлалын варрантыг гаргасан. Санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд Компани \$64,273 долларын зардал гаргаж, нийтдээ \$6,964,785 долларын цэвэр санхүүжилт татсан.

Варрант

2021, 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон есөн сарын хугацаа дахь варрантын мэдээллийг доор харуулав:

	2022.09.30		2021.09.30	
	Варрантын тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ	Варрантын тоо	Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ
1 сарын 1-ний байдлаар	44,845,052	\$ 0.60	75,097,796	\$ 0.55
Гаргасан	12,203,670	0.45	-	0.30
Хэрэгжсэн	-	-	(5,803,750)	0.30
Хугацаа дууссан	(44,845,052)	0.60	(22,599,194)	0.55
9 сарын 30-ны байдлаар	12,203,670	\$ 0.45	46,694,852	\$ 0.59
9 сарын 30-ны байдлаар хэрэгжих боломжтой	12,203,670	\$ 0.45	46,694,852	\$ 0.59

2022 оны 9 сарын 30-ны байдлаар хэрэгжих боломжтой варрантын хугацаа 2024 оны 7 сарын 8 болон 2024 оны 8 сарын 4-ний хооронд дуусна.

Хувьцааны опцион

Компани тогтмол 10%-ийн опционы урамшууллын хөтөлбөр ("Хөтөлбөр") хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү хөтөлбөрийн хүрээнд Компанийн ТУЗ-ийн гишүүд, удирдлага, ажилтан албан тушаалтнууд компанийн хувьцааг худалдан авах опционыг худалдан авч, хэрэгжүүлэх боломжтой. Опционыг хэрэгжүүлэх, олгох нөхцөлүүдийг ТУЗ тодорхойлно. Опционыг олгохдоо нөхцөлийг өөрөөр заагаагүй бол олгосон өдрөөс эхлэн шууд хэрэгжүүлэх боломжтой. Төлөвлөгөөний хүрээнд энгийн хувьцааны хувьд олгох опцион нь Компанийн гаргасан болон зах зээлд энгийн хувьцааны 10%-аас хэтрэхгүй байх ба опционыг олгох шийдвэр гаргах үед нэг хүнд 5%-аас илүү олгох эрхгүй (хорогдуулахгүй байдалд үндэслэдэг).

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

2021 болон 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын тайлан

10. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө (үргэлжлэл)

2021, 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон есөн сарын хугацаанд үнэт цаасны опционд гарсан өөрчлөлтүүд:

	2022.09.30		2021.09.30	
	Опционы тоо	Жигнэсэн дундаж үнэ	Опционы тоо	Жигнэсэн дундаж үнэ
1 сарын 1-ний байдлаар	15,855,000	\$ 0.45	13,790,000	\$ 0.46
Олгосон	4,180,000	0.31	3,825,000	0.38
Хугацаа дууссан	(2,595,000)	0.87	(960,000)	0.36
Хэрэгжүүлсэн	(60,000)	0.29	(900,000)	0.35
9 сарын 30-ны байдлаар	17,380,000	\$ 0.36	15,755,000	\$ 0.45
9 сарын 30-ны байгдлаар хэрэгжих боломжтой	17,380,000	\$ 0.36	15,755,000	\$ 0.45

Ирээдүйд олгогдох хувьцааны эрх

Ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрийг Компани 2013 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, албан тушаалтнуудыг урамшуулах хувьцааны опционы төлөвлөгөөтэй адил урт хугацааны хөрөнгө оруулагчдын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ирээдүйд олгогдох хувьцааны нэгжийн тоо ширхэг хугацааг ТУЗ тодорхойлох бөгөөд дээрх эрхийг нөхөн төлбөр, урамшуулал болгох эсэхийг мөн тодорхойлно. Олгосон өдрөөс ирээдүйд олгогдох хувьцааны эрхийг шууд хэрэгжүүлэх боломжтой. Хугацаа дуусгавар болох, эсвэл хөтөлбөрт хамрагдсан гишүүн нас барсан тохиолдолд Компани тухайн гишүүний хувийг бэлэн мөнгөөр эсвэл үнэт цаасаар зах зээлийн үнэлгээгээр худалдан авах боломжтой. Энэ нь Компанийн сонголтоор хийгдэх бөгөөд Компани бэлэн мөнгөөр худалдан авахгүйгээр шийдвэрлэвэл энэхүү төлөвлөгөө нь үнэт цаасанд суурилсан хөтөлбөрт шилжинэ.

2021, 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон тайлант үеийн байдлаар ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн тухай мэдээлэл:

	2022.09.30	2021.09.30
	Тоо ширхэг	Тоо ширхэг
1 сарын 1-ний байдлаар	6,103,362	5,032,836
Олгосон	958,301	893,504
9 сарын 30-ны байдлаар	7,061,663	5,926,340

	2022.09.30		2021.09.30	
Олгогдсон өдрөөс тооцоолсон 5 өдрийн жигнэсэн дундаж үнэ	\$	0.32	\$	0.38

Хувьцаанд суурилсан урамшуулал

2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон есөн сарын хугацаанд Компани нь \$921,712 (2021 – \$988,538) долларын хувьцаанд суурилсан урамшууллын нэгтгэсэн алдагдалд тооцсон.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

2021 болон 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын тайлан

11. Хайгуул болон үнэлгээний зардал

2021 болон 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын хайгуул болон үнэлгээний зардлын мэдээллийг дор харуулав:

	9.30-нд дуусгавар болсон 3 сар		9.30-нд дуусгавар болсон 9 сар	
	2022	2021	2022	2021
Элэгдэл, хорогдол	\$ 25,206	\$ 8,540	\$ 71,917	\$ 23,709
Шууд зардал	554,730	1,028,533	2,106,940	1,473,168
Ажилтан, албан тушаалтнуудын урамшуулал	207,482	198,901	562,796	332,232
Хувьцаанд суурилсан урамшуулал	367,831	129,865	407,304	419,635
	\$ 1,155,249	\$ 1,365,839	\$ 3,148,957	\$ 2,248,744

12. Ерөнхий ба захиргааны зардал

2021 болон 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын ерөнхий ба захиргааны зардлын мэдээллийг доор харуулав:

	9.30-нд дуусгавар болсон 3 сар		9.30-нд дуусгавар болсон 9 сар	
	2022	2021	2022	2021
Захиргааны үйлчилгээ	\$ 258,936	\$ 209,109	\$ 552,817	\$ 412,938
Элэгдэл, хорогдол	9,526	9,369	28,573	27,905
ТУЗ-ийн гишүүдийн төлбөр, зардал	25,250	29,458	94,504	80,381
Хөрөнгө оруулагчтай харилцах, маркетинг	33,576	54,702	100,885	169,176
Оффис, бусад	26,098	22,570	76,580	70,218
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	100,211	57,172	266,325	184,492
Зохицуулагч байгууллагын төлбөр, зардал	13,796	12,925	114,353	77,622
Хувьцаанд суурилсан нөхөн олговор	395,887	168,510	514,408	568,903
Томилолтын зардал	7,007	1,277	42,887	2,588
	\$ 870,287	\$ 565,092	\$ 1,791,332	\$ 1,594,223

13. Санхүүгийн хэрэгслүүд

Зээлийн эрсдэл:

Зээлийн эрсдэл нь санхүүгийн хөрөнгийн хамгийн өндөр эрсдэлийг агуулдаг. Тайлагнах өдрөөр тасалбар болгон зээлийн эрсдэл нь хамгийн их өндөр байгаа нь:

	Бүртгэгдсэн дүн	
	9.30 2022	12.31 2021
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах	\$ 2,980,543	\$ 7,063,051
Авлага	52,323	23,784
	\$ 3,032,866	\$ 7,086,835

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2021 болон 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын тайлан

13. Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

Компани нь бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг Канад Улсын тэргүүлэгч санхүүгийн байгууллагуудад байршуулж, зээлийн эрсдэлийг удирддаг. 2022 оны 9 сарын 30-нд бэлэн мөнгөний үлдэгдлийн 5% буюу \$144,686 кан.долларыг Канад Улсаас гадуурх банкуудад байршуулсан. (2021 оны 12 сарын 31 - \$270,113 буюу 3%).

Төлбөрийн чадварын эрсдэл:

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. Компани нь энэхүү эрсдэлийг удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг.

Зах зээлийн эрсдэл:

Зах зээлийн эрсдэл гэж үнэт цаасны ханш, таваарын зах зээл, валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай эрсдэлүүдийг хэлнэ.

а) Хүүгийн эрсдэл

2022 оны 9 сарын 30-ны байдлаар Компани нь хүүтэй зээл байхгүй тул хүүгийн эрсдэлд өртөхгүй болно.

б) Гадаад валютын эрсдэл

Компанийн үйл ажиллагааны голлох валют нь канад доллар бөгөөд охин компаниудын голлох валют нь монгол төгрөг юм. Түүнээс гадна, Компани нь америк доллараар санхүүжилт авч, зардлыг гаргасан. Иймээс канад долларын бусад валюттай харьцах хэлбэлзэл нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөр болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлөх боломжтой. Валютын хөрвөх эрсдэл бүхий санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдэд ам.доллараар илэрхийлэгдэх бэлэн мөнгө, өглөг, хуримтлагдсан өр төлбөр, монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн бэлэн мөнгө, өглөг болон хуримтлагдсан өр төлбөр багтаж байна. Компани нь Канад Улсын банкуудад канад болон ам.доллар байршуулдаг.

Компанийн гадаад валют (ам.доллар)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

	9.30 2022	12.31 2021
Мөнгөн болон түүнтэй адилтгах	\$ 165,053	\$ 3,373,167
Худалдаа, бусад төлөгдөх	(175,415)	(334,937)
	\$ (10,362)	\$ 3,038,230

Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$1,000 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай (2021 оны 12 сарын 31 - \$303,800).

Компанийн гадаад валют (төгрөг)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав:

	9.30 2022	12.31 2021
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 24,539	\$ 19,012
Худалдаа, бусад авлага	45,300	19,198
Худалдаа, бусад өглөг	(40,144)	(99,422)
	\$ 29,695	\$ (61,212)

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Завсрын үеийн Хураангуй, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулагдаагүй)

2021 болон 2022 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын тайлан

13. Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

Монгол төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт \$3,000 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай. (2021 оны 12 сарын 31 - \$6,100).

с) Үнийн эрсдэл

Компанийн санхүүгийн хэрэгслүүд нь эрдсийн хайгуул, олборлолтын салбарын таваарын үнийн хэлбэлзлээс бусад байдлаар үнийн шууд эрсдэлд орох магадлал багатай.

14. Холбогдох талууд

Компанийн голлох удирдлагын ажилтнуудад ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх албан тушаалтнууд багтдаг. Эдгээр голлох удирдлагын ажилтнуудын цалин урамшууллыг доор харуулав:

	9 сарын 30	
	2022	2021
ТУЗийн гишүүдийн цалин	\$ 93,750	\$ 92,663
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	255,625	247,000
Ажилтнуудын цалин, урамшуулал	1,163,036	989,498
Голлох албан тушаалтнуудын хувьцаанд суурилсан	311,598	270,869
	\$ 1,824,009	\$ 1,600,030

Орчуулга: Энэхүү тайлан нь Англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, Монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх мэдээлэл гарвал Англи хэл дээрх хувийг мөрдөнө.